

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨРИЙН ӨМЧИТ  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 05 дугаар сарын 24

Дугаар ХЭХТ 20/02

Улаанбаатар хот

**“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн  
дүрэмд өөрчлөлт оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн дүрмийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 1.7 дахь заалтыг “Компанийн байршил нь Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Бага тойруу /14200/ Их эзэн чингис хааны нэрэмжит талбай гудамж, 8/1 дугаартай барилгын 8 дугаар давхрын 801 тоот хаягт, 75114323 утасны дугаартай дүрэмд заасан үйл ажиллагаа эрхэлнэ” гэж өөрчилж, хавсралтаар баталсугай.

2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Л.Цэнгүүнжавд даалгасугай


**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ:**

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:


ИРГЭНИЙ НИСЭХИЙН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ  
ГАЗЫН ДАРГА

 Ч.МӨНХТУЯА


ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

  
118268063 5919487 СБТ9513  
Н.БАТ-ЭРДЭНЭ

ИНЕГ-ЫН ДЭД ДАРГА

 Б.АЛТАНЦОМ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН АХЛАХ РЕФЕРЕНТ


 Н. МӨНХБАТ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Ц.БАЯР-ЭРДЭНЭ

УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН УДИРДЛАГА,  
ТӨЛӨӨЛЛИЙН АЛБАНЫ ДАРГА

 В.ДАРХАНБААТАР

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал”  
ТӨХХК-ийн 2022 оны 05 дугаар сарын 24-ний  
өдрийн 13 дугаар тогтоолын хавсралт  
13/11/22/102

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨРИЙН ӨМЧИТ  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү дүрэм нь “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “Компани” гэх)-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.2. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол шийдвэр, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.4. Компани нь “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээд /цаашид “Хамтарсан компани” гэх/-ийн төрийн мэдлийн 49.0 хувийн хувьцааг эзэмшигч байна.

1.5. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани нь 100 хувь төрийн өмчит бөгөөд 2 (хоёр) хувьцаа эзэмшигчтэй хуулийн этгээд болно. Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Зам, тээврийн хөгжлийн яам нийт хувьцааны 66.0 (жаран зургаан) хувь, (цаашид “Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэх), Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 34.0 (гучин дөрвөн) хувь, (цаашид “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэх) байна.

1.6. Компанийн оноосон нэр нь Монголоор “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр нь “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК, англиар “Khushigiin khundii airport” state owned limited liability company, товчилсон нэр нь “Khushigiin khundii airport” State owned LLC болно.

1.7. Компанийн байршил нь түүний гүйцэтгэх удирдлагын байрлаж буй хаягаар тодорхойлогдох бөгөөд гүйцэтгэх удирдлага нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Бага тойруу /14200/ Их эзэн чингис хааны нэрэмжит талбай гудамж, 8/1 дугаартай барилгын 8 дугаар давхрын 801 тоотод, 75114323 утасны дугаартайгаар дүрэмд

заасан үйл ажиллагаа эрхэлнэ. Хаягийн өөрчлөлтийг компанийн гүйцэтгэх удирдлага тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

1.8. Компани өөрийн тэмдэг, бэлгэдэлтэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

1.9. Тэмдэг, бэлгэдлийн загварыг баталж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн Компани эдэлнэ.

1.10. Компанийн тэмдгийг компанийн гүйцэтгэх удирдлага, эвсэл компанийн гүйцэтгэх удирдлагаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшнэ.

## **ХОЁР. КОМПАНИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

2.1. Компанийн үндсэн зорилт нь нисэх буудлаар үйлчлүүлэгчдэд олон улсын стандарт, шаардлагын түвшинд хүрсэн, аюулгүй байдлыг бүрэн хангасан, тав тухтай нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, нисэх буудлын хэвийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, галын болон аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах замаар Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, ашигтай ажиллагааг хангахад оршино.

2.2. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх Япон, Монголын хамтарсан хуулийн этгээд /цаашид “Хамтарсан компани” гэх/-ийн Монгол Улсын төрийн мэдлийн 49 хувийн хувьцааг эзэмшигчийн эрх үүргийг Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон холбогдох гэрээний хүрээнд хэрэгжүүлнэ.

2.3. Компани нь үндсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагаа явуулна:

2.3.1. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын төрийн үйлчилгээний Хүндэт зочны танхим /586 кв.м/-ын үйл ажиллагааг эрхлэх;

2.3.2. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал дахь агаарын хөлгийн ангарын болон бусад барилга байгууламжийн менежментийг хэрэгжүүлэх;

2.3.3. Хамтарсан компанид ашиглуулахаас бусад нисэх буудлын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах;

2.3.4. Тусгай хэрэгцээний газрыг Хувьцаа эзэмшигчээс эрх олгосноор газар ашиглах гэрээ байгуулах;

2.3.5. Өөрийн болон хамтарсан компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй, хамааралгүй нисэх буудлын үйл ажиллагааны чиглэлээр бизнесийн болон менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

2.3.6. Хамтарсан компанийн үйл ажиллагаанд хамааралгүй “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ын бусад үйл ажиллагаа.

2.4. Компани нь үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, бусад үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана.

2.5. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрлийг авна.

2.6. Компани нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

2.7. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагааг Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу явуулна.

## **ГУРАВ. КОМПАНИЙН ХӨРӨНГӨ ХУВЬЦАА**

3.1. Компанийн өөрийн хөрөнгө хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 493,738,543 (дөрвөн зуун ерэн гурав сая долоон зуун гучин найман мянга таван зуун дөчин гурав) ширхэг энгийн хувьцаатай байна. Хувьцааны үнэ, тоо хэмжээнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

3.2. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж болно.

3.3. Компани нь цаашид нэмж хувьцаа болон бусад үнэт цаас зарлах бол тэдгээрийн тоо, гаргах хугацаа, нөхцөлийг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

## **ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ**

4.1. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана.

4.2. Ногдол ашиг хуваарилах асуудлыг Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

## **ТАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА**

5.1. Компанийн удирдлага дараах бүтэцтэй байна.

5.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал;

5.1.2. Гүйцэтгэх удирдлага;

## **ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит, ээлжит бус байна.

6.2. Компанийн Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Монгол Улсын Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 66.0 (жаран зургаан) хувь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 34.0 (гучин дөрвөн) хувь /цаашид "Хувьцаа эзэмшигч" гэнэ/ хэрэгжүүлнэ.

6.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар тэмдэглэл хөтөлнө.

6.4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

6.4.1. Компанийн дүрэм батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

6.4.2. компанийн хэлбэрийг өөрчлөх;

6.4.3. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

6.4.4. компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох;

6.4.5. Компанийн бизнес төлөвлөгөөг батлах;

6.4.6. Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах;

6.4.7. Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн бодит үнийг тогтоох;

6.4.8. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүнтэй байгуулах контрактын гэрээний нөхцөл, олгох цалин, урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах шийдвэр гаргах;

6.4.9. Компанийн аудитын байгууллагыг болон дотоод аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, компанийн тайлан тэнцэлд хийсэн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

6.4.10. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

6.4.11. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

6.4.12. компанийн тухай хуульд заасан бусад асуудал;

6.5. Хувьцаа эзэмшигчдийн хуралд энэхүү дүрмийн 1.5, 6.2-д заасан эрх бүхий байгууллага нь зохих ёсоор эрх олгогдсон бүрэн эрхт төлөөлөгч болон төлөөлөгчдөөрөө дамжуулан оролцоно. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хуульд заасан журам, нөхцөлийн дагуу зохион байгуулна.

## **ДОЛОО. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА**

7.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон түүнтэй байгуулсан контрактын гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь компанийн гүйцэтгэх захирал байна.

7.2. Гүйцэтгэх захирлыг Хувьцаа эзэмшигчдийн хурал томилж, чөлөөлнө.

7.3. Гүйцэтгэх захирал нь Хувьцаа эзэмшигчидтэй байгуулсан контрактын гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд хувьцаа эзэмшигч Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас томилогдсон Төрийн өмчийн төлөөлөгчид гарын үсэг зурна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөдөлмөрийн хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

7.4. Гүйцэтгэх захирал нь Хувьцаа эзэмшигчдээс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

7.5. Гүйцэтгэх захирал нь компанийн ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх асуудлыг Хувьцаа эзэмшигчидтэй зөвшилцөнө.

7.6. Өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагааны талаар Гүйцэтгэх захиралд зөвлөх эрх бүхий Захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг Гүйцэтгэх захирал батална.

7.7. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдож үүссэн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцоно.

7.8. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна.

7.8.1. Менежментийн ур чадвартай, 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажил гүйцэтгэж байсан, удирдлагын зохих туршлагатай, дээд боловсролтой байх;

7.8.2. Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

7.8.3. Ял шийтгэлгүй байх;

7.8.4. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;

7.9. Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ.

7.9.1. Хувьцаа эзэмшигчдийн өмнө Компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд хоёроос доошгүй удаа ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;

7.9.2. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

7.9.3. Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулж, түүний хэрэгжилтийг зохион байгуулах;

7.9.4. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

7.9.5. Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

7.9.6. Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан Компанийг удирдах;

7.9.7. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

7.9.8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

7.9.9. Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

7.9.10. Компанийн үйл ажиллагааны дотоод журмыг баталж мөрдүүлэх;

7.9.11. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;

7.9.12. Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх, үндсэн хөрөнгийн асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

7.10. Гүйцэтгэх захирал нь Хувьцаа эзэмшигчдийн хурлаас олгосон зөвшөөрлийн дагуу зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр Компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **НАЙМ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН**

8.1. Компанийн гүйцэтгэх захирал, нэгжийн дарга, ерөнхий нягтлан бодогчийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

8.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэмд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

8.3. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг компанитай байгуулсан гэрээ, компанийн дотоод журмаар тогтоох бөгөөд байгуулсан гэрээ, тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

8.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд зааснаар үүрэг, хариуцлага хүлээнэ.

## **ЕС. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО**

9.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

9.1.1. Өмчлөгчийн хяналт;

9.1.2. Дотоод аудитор;

9.1.3. Хөндлөнгийн аудит;

9.2. Өмчлөгчийн хяналтыг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

9.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага компанийн дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган, үйл ажиллагаагаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

9.4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа энэхүү дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдэлнэ.

9.5. Компанийн дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын томилсон Дотоод аудитор хэрэгжүүлнэ.

9.6. Дотоод аудитор нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг туршлагатай байх бөгөөд Гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

9.7. Дотоод аудитор нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах мэдээлэх үүрэгтэй.

9.8. Компанийн хөндлөнгийн аудитыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгосон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар хийлгэнэ.

9.9. Хөндлөнгийн аудитын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

## **АРАВ. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ**

10.1. Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 87, 88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

10.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 89, 91, 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

10.3. Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэхүү дүрмийн 10.1, 10.2-т заасан хэлцлийн талаарх мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

## **АРВАН НЭГ. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАН**

11.1 Компани нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан Хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулах бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч хариуцна.

11.2 Компани нь хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба алдагдлын тайлангаа компанийн Хувьцаа эзэмшигчид болон холбогдох хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээдэд танилцуулна.

11.3. Компанийн санхүүгийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ээс эхэлж 12 дугаар сарын 31-нээр дуусна.

## **АРВАН ХОЁР. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

12.1. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

12.2. Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

12.2.1. Баланс;



- 12.2.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;
  - 12.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан;
  - 12.2.4. Хуримтлагдсан ашиг;
  - 12.2.5. Өмчийн өөрчлөлтийн тайлан;
  - 12.2.6. Тухайн тайлангийн хугацаанд байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр, төрөл, үнийн дүнгийн хамт;
  - 12.2.7. Нэмэлт тайлбар, тодруулга;
  - 12.2.8. Санхүүгийн тайлангийн тодруулга;
  - 12.2.9. Эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин, урамшууллын дүн, албан тушаалтан нэг бүрээр гаргах;
  - 12.2.10. Хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл.
- 12.3. Санхүүгийн тайланг компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд хувьцаа эзэмшигчид санхүүгийн тайланг хурлаараа хэлэлцэнэ.

### **АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ**

- 13.1. Компани нь дараах бичиг баримтыг хадгалах үүрэгтэй:
- 13.1.1. Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
  - 13.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн дотоод баримт бичиг;
  - 13.1.3. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;
  - 13.1.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, Компанийн гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй бусад гэрээ, түүний биелэлттэй холбогдох баримт бичиг;
  - 13.1.5. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, контрактын болон хөдөлмөрийн гэрээ;
  - 13.1.6. Аудитын дүгнэлт;
  - 13.1.7. Хувьцаа болон үнэт цаас гаргах журам;
  - 13.1.8. Эрх бүхий албан тушаалтан болон нийт ажилчдад олгосон цалин, урамшуулал, шагналтай холбоотой бичиг баримт;
  - 13.1.9. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;

13.1.10. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

13.1.11. Бусад баримт бичиг.

13.2. Компани нь өөрийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг байнга хадгална. Бусад баримт бичгийг 5 жилийн хугацаатай хадгалах, баримт бичгийн хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

13.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал, компанийн хувьцаа болон үнэт цаас гаргах, компанийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлттэй холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивт шилжүүлэх ажиллагааг архив, бичиг хэргийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

13.4. Компанийн талаарх мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд түүнтэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуулийн 98, 99 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

#### **АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАХ**

14.1. Компанийг Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгана.

14.2. Татан буулгах комисс томилогдсоноор Компанийн гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

#### **АРВАН ТАВ. БУСАД**

15.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

15.2. Энэхүү дүрэм болон түүнд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн эхийг компани дээр хадгална.

15.3. Энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэхүү дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

---ooOoo---